




**ЭКОСУМ**

## **САНХҮҮГИЙН ТАЙЛАН**



**2021 ОН**

## ТАНИЛЦУУЛГА

Энэхүү санхүүгийн тайланд 2021 оны 1 сарын 1нээс 2021 оны 12 сарын 31нийг хүртэлх Эко сум ТББ-ын нийт орлого, эх үүсвэр, зардлын задаргааг харуулав.

## ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭР


2021 оны Эко сум ТББ-ын нийт орлого 489'596'920 төгрөг. Энэхүү орлогын хэмжээнд 2021 оноос эхлэн хэрэгжиж буй Эко барилгын төсөл болон 2020 онд эхлээд байсан Хог хаягдлын менежментийн төслийн орлого багтсан болно.

Орлого нь 100 хувь байгууллагуудын буцалтгүй тусламж, олон нийтийн хандив болон гишүүдийн татвараас бүрдсэн болно. Гишүүдийн татвар болон олон нийтийн хандив 300'000 төгрөг орлогын дүнд багтсан болно.

Орлогын эх үүсвэрээр:


- Европын холбоо (SWITCH-Asia II хөтөлбөр): 315'223'220 төгрөг.
- Люксембургийн Байгаль Цаг уур, Тогтвортой Хөгжлийн яам: 148'687'500 төгрөг.
- Хишиг-Өндөр сумын ЗДТГ: 15'000'000 төгрөг.
- Азийн сан: 10'386'200 төгрөг.

Өмнөх оны тайлант үеийн үлдэгдэл 155'171'900 төгрөг ба 2021 оны нийт санхүүгийн эх үүсвэрүүдийн нийлбэр буюу 2021 оны нийт төсөв 644'768'820 төгрөг байна.




## НИЙТ ЗАРДАЛ

Эко сум ТББ-ын нийт зардал 569'567'021 төгрөг. 2021 оны нийт төсөв 75'201,799 төгрөг ба 2021 онд Эко Сум ТББ 2 төсөл хэрэгжүүлсэн байна. Нийт зардлын 58 хувь буюу 332'244'365 төгрөгийг Хог хаягдлын менежментийн төсөлд, 35 хувь буюу 196'986'322 төгрөгийг Эко барилгын төсөлд зарцуулсан байна. Ерөнхий үйл ажиллагааны зардалд энэ оны нийт зардлын 7 хувь буюу 40'336'434 төгрөгийг зарцуулсан байна.




Дээрх төслүүдийн зардлыг нэгтгэсэн дүнгээс 54 хувийг нь тоног төхөөрөмж, материалд, 43 хувийг хүний нөөцийн зардалд, 2 хувийг томилолтонд зарцуулжээ.



## ЕРӨНХИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

Ерөнхий үйл ажиллагааны зардалд харьяалагдах нийт зардлаас материал хангамжын зардал 27'632'062 төгрөг байна.

Мөн хүний нөөцийн зардал нь дээрх зардлын 11'932'246 төгрөг буюу 30 хувийг эзэлж байна. Оффис болон харилцаа холбооны зардал болон томилолтын зардал нь нийт зардлын тус бүр 1 хувийг эзэлж байна.




## ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨСЛИЙН ЗАРДАЛ

Хог хаягдлын менежментийн төслийн зардлын 49 хувийг (164'133'286 төгрөг) хүний нөөцийн зардал эзэлж байгаа бөгөөд төслийн зохицуулагч, техникийн зөвлөх, барилгын инженер, санхүүгийн ажилтан зэрэг 4 хүнийн цалингаас бүрдэж байна. Үүнээс гадна хог ангилах сав хийхэд хөлсөлсөн гэрээт ажилчдын цалин болон хог хаягдлын менежментийн төв дээр ажилласан ажилчдын хөлс нь энэхүү цалингийн зардлын өсөлтөнд нөлөөлжээ.

Материал хангамжын зардал нь төслийн нийт зардлын 48 хувийг (158'630'120 төгрөг) эзэлж байна. Хог хаягдлын менежментийн тавийн барилгын түүхий эд материал, тоног төхөөрөмж, өрхийн хог ангилах савны материал хангамж зэрэг нь голлох зардалд тооцогдож байна.

Хог хаягдлын менежментийн барилгын ажил явагдах үед, барилгын ажлын үеэр хийсэн худалдан авалтын томилолтын зардлаас дийлэнх томилолтын зардал бүрдэж байна. Томилолтын зардлын нийт дүн 6'885'018 төгрөг.



## ЭКО БАРИЛГЫН ТӨСЛИЙН ЗАРДАЛ

Эко барилгын төслийн зардлын 62 хувийг (122'020'699 төгрөг) материал хангамжын зардал эзэлж байна. Энэ зардал нь шахмал шавар тоосгоны үйлдвэрлэл эхлэхээс өмнөх сургалт, түүнд шаардагдах тоног төхөөрөмж мөн хамгийн эхний загвар барилгын түүхий эд материалын зардалтай холбогдон гарсан.

Хүний нөөцийн зардал нь хог хаягдлын менежментийн төслийн зардалтай нэгэн адилаар бүтэн цагийн 3 ажилтнаас гадна 2021 онд баригдсан хамгийн анхны загвар барилгат ажилласан нийт ажилчдын цалин багтсан. нь төслийн зохицуулагч, техникийн ажилтан, санхүүгийн ажилтан нийт 3 хүний цалингаас бүрдэж байна.

Томилолтын зардлын дийлэнх нь Улаанбаатар хотруу явсан худалдан авалтын үеийн зардлуудаас бүрдэнэ. Нийт зардлын дүн 4'426'321 төгрөг.

